

Мэдэмхий шүүхийг халж, мэргэн шүүхтэй больё



[”Өдрийн сонин”](#)

2004/07/29 - № 187 (1689)

1. Шүүх бол гуравдугаар зэрэглэлийн биш, гурав дахь засаг мөн

Төр, эрх зүй (хууль) хоёрын аль нь анхдагч вэ гэдэг нь энгийн ухамсарын түвшинд бол тахиа, өндөг хоёрын аль нь анхдагч вэ гэдэгтэй төсөөтэй асуулт юм. Монголчууд бид хуулийг биш, төрийг буюу чухамдаа хааныг дээдэлж ирсэн түүхэн уламжлалтай, тэр сэтгэлгээ одоо ч үргэлжилсэн хэвээр. Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар бид эрх зүйт төр бүхий иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго дэвшүүлсэн билээ. Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлд иргэн нь төрийг биш, харин “үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэнэ” гэжээ. Тэгэхээр төр хэдийгээр хуулийг батлан гаргадаг боловч нэгэнт баталсан хуульдаа өөрөө эргээд захирагддаг жамтай. Өөрөөр хэлбэл, төрийн эрх мэдэл хуулиар хязгаарлагдаж байх ёстой гэсэн үг. Эс тэгвээс төр дарангуйлагч болж хувирдаг. Үүнээс сэрэмжлэхийн тулд төрийн эрх мэдлийг хуваах онол, зарчим үүссэн бөгөөд манай улсын шинэ Үндсэн хууль уул эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаанд хувааж, тэдгээр нь адил тэнцүү байх механизмыг тогтоосон. Түүнээс хойш нэгэнтээ арван хоёр жил өнгөрчээ. Нэг бодоход энэ бол бага хугацаа биш. Энэ хооронд урьд нь манайх шиг социалист гэгдэж байсан нэлээд улс оронд шүүхийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс доогуургүй түвшинд ойлгож хүлээж авдаг эрх зүйн ухамсар төлөвшиж буй нь илтэд мэдрэгдэх болсон байна. Гэтэл манайхан Улсын Их Хурал, Засгийн газар хоёрыг л төр засаг гэж ойлгоод шүүхийг салбарын нэг яам, газрын хэмжээнд үнэлж үзээд байх шиг. Ямар сайндаа л Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыгаа “төрийн гурван өндөрлөг” гэж нэрлэж байхав дээ. Зүй нь УИХ, Засгийн газар (Ерөнхийлөгчийг оролцуулан), Дээд шүүх (Цэцийг оролцуулан) гурвыг л ингэж нэрлэх учиртай юм шүү дээ. Гэхдээ угаас манайд шүүх нь төрийн эрх мэдлийн бие даасан салаа байж үзээгүй, тийм уламжлал ч байхгүй учраас бас арга ч үгүй биз. 1980-аад оны дундуур намайг аймгийн прокурор байхад аймгийн захиргааны дарга нь шүүхийн даргыг “чи бол аймгийн захиргааны нэг хэлтсийн даргын рангийн хүн шүү” гээд хөдөө яв гэж тушааж байсан нь санаанаас гардаггүй юм.

Тэгэхээр шүүх эрх мэдлийн талаарх ухамсарыг хэрхэн шинэтгэж, шүүхийг байх ёстой түвшинд нь яаж хүргэх вэ? Юуны түрүүнд шүүх өөрийн хууль ёсны, зарчимч, хэлбэрэлтгүй, чин шударга үйл ажиллагаагаар өөрийн байр суурийг төрийн тогтолцоонд “байлдан” эзэлж авах ёстой. Шинэ шүүхийн нийгмийн гол үүрэг нь нийгэмд эрх зүйн ноёрхол, шударга ёсыг тогтоох, түүний дотор төр өөрөө хуульд захирагддаг (хуулийн дор оршдог) байх явдлыг хангахад оршино. Үүний тулд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн алинд ч байхгүй онцгой бүрэн эрхийг шүүхэд олгосон байдаг. Жишээлбэл, зөвхөн шүүх¹ л хүний эрх чөлөөг хязгаарлах (хорих), амьд явах эрхийг хасах (цаазаар авах ял оногдуулах), өмч хөрөнгийг хураах, улс төрийн намын үйл ажиллагааг зогсоох буюу намыг тараах, парламент болон засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй. Парламент нь нийт ард иргэдээс сонгогдсон байдал, хууль тогтоох эрх мэдлээрээ, засгийн газар нь хөрөнгө мөнгө, албадлагын байгууллагаараа хүчирхэг байдаг бол шүүхийн сүр хүч нь гагцхүү шүүх л шударга үнэн, хууль ёсыг тогтоогч мөн гэсэн хүмүүсийн итгэл үнэмшил нийгэмд бүрэлдэн тогтсон байхад л оршино гэж үздэг. Шүүх эрх мэдэлд үүнээс өөр хүч байхгүй. Нийгэмд хүмүүсийн ийм ухамсар итгэл төлөвшөөгүй бол шүүх нь доожоогүй, сул дорой хэвээр байна гэсэн үг. Чухамдаа төрийн эрх мэдлийн нөгөө хоёр байгууллагын хууль бус актыг цуцалдгаараа л шүүх нь тэдгээрээс хараат бус, бие даасан гурав дахь засаг гэдгээ харуулдаг юм. Нөгөө талаас шүүх засаг гэж байхын нийгмийн ач холбогдол нь хууль тогтоогч болон гүйцэтгэгч нар засгийн эрх мэдлийг хэт төвлөрүүлэн дур зоргоор авирлахаас иргэдийг хамгаалах явдал байдаг.

¹ Үүнд Үндсэн хуулийн Цэцийг мөн хамруулав.

2. Шүүхийн одоогийн дүр төрх

Шинэ Үндсэн хуулиар шүүхүүд Монголын засгийн гурван салааны нэг мөн гэдгээ илтгэн харуулах эрх зүйн боломж бий болсон. Гагцхүү тэр боломжийг амьдралд яаж хэрэгжүүлэх вэ, хэрэгжүүлж чадаж байна уу, үгүй юу гэдэгт л хамаг учир оршино. Эдүгээ нийгэмд шүүх, шүүгчийн нэр хүнд сайнгүй байна. Хэрэг маргааныг хуульд нийцүүлэн шударгаар шийдвэрлэдэггүй, авилгад автагдсан, мэдлэг сул гэх мэт шүүмжлэл зонхилдог. Энэ бүхний шалтгаан юунд оршино вэ? Бидний ажигласнаар гол шалтгаан нь шүүгчдийн өөрсдийнх нь үйл ажиллагаа, хувийн зан чанар, байр суурьтай холбоотой. 1992 оны Үндсэн хуулиар шүүхийг төрийн бусад “өндөрлөг”-тэй нэгэн түвшинд өргөмжилсөн боловч тэнд ажиллах хүмүүсийн сэтгэлгээ, чадвар нь тэр түвшинд хүрэх болоогүй байсан тул олонх шүүгчийн хувьд суудал нь томдож, ажил мэргэжилдээ өсч дэвжихээс түрүүнд биеэ тоох, эрх мэдлээ буруу ашиглах нь давамгайлах болсон. Нэгэн мэргэн хүний хэлсэнчлэн “том суудал том хүнийг улам том болгодог бол жижиг хүнийг улам жижиг болгодог” ёсоор нөхдүүд шүүгчийн хараат бус байдал гэдгийг “би хэнээс ч, юунаас ч хамааралгүй юм байна” хэмээн туйлшруулж, хэрэг маргааныг хуульд захируулан шийдвэрлэхийн оронд өөрийн (захиалагчийн) хүсэлд нийцүүлдэг гажуудалд автагдаж эхэлсэн. Шинэ Үндсэн хуулийн дараа шүүхийг бүрдүүлэхдээ үндсэнд нь хуучин шүүгчдээ эргүүлээд томилсон учир бие бүрэлдэхүүний хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй. Хуучин тогтолцооны үед Дээд шүүх нь шүүн таслах ажиллагааны төдийгүй захиргаа, боловсон хүчний удирдлагыг эрхэлж байсныг шинэ тогтолцоогоор гэнэт халж, шинэ зарчим, тогтолцоонд шилжихэд шүүгч нар мэдлэг боловсрол, сэтгэл зүйн хувьд бэлэн биш байсан нь тодорхой. Энэ үеэс шүүгчийн цорын ганц “дарга” нь хууль байх ёстой гэх болсон. Гэтэл “шүүгч гагцхүү хуульд захирагдана” гэдэг зарчим нь шүүгч нарын хувьд хуулийг өөр өөрийн хүсэлд нийцүүлэн дур зоргоор тайлбарлан хэрэглэх явдлаар солигдсон гэхэд хэтрүүлэг болохгүй. Хэрэг маргааныг илтэд буруу шийдвэрлэх явдал жил ирэх тусам улам олширч, түүнийхээ төлөө шүүгч ямар ч зэм хариуцлага хүлээдэггүй, чухам яагаад тэгж шийдвэрлэсэн үндэслэлээ ч шийдвэртээ заахаа больсон². Ямар ч зөв, гарцаагүй үндэслэл гаргаж заргалдаад нэмэргүй, ёстой нөгөө “илжигний чихэнд алт хийсэн ч сэгсэрнэ, ус хийсэн ч сэгсэрнэ” гэгчээр дүлий дүмбэ оргиод, эрх мэдлийн хар хүчээр муйхарлан зүтгээд үнэнд дийлдэхгүй. Доод шатны шүүхийн алдаатай шийдвэрийг засч залруулах үүрэгтэй дээд шатны шүүх нь болж л өгвөл хамгаалаад өнгөрнө. Байгууллагархах, өөрийгөө хамгаалах зөн совиндоо хөтлөгдөн хууль ёс, хүний эрх ашгийг золиослож байгаа нь тэр. Ийм нөхцөлд хэргээ шийдүүлэх гэсэн хэн боловч ёстой л дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу гэгч болж, доголонгийн газар доголон явахын үлгэрээр аргагүйн эрхэнд шүүгчид “түлхүүр тааруулдаг” болжээ. Улмаар шүүгч хуульд биш, сонирхогчийн хууль бус захиалгад хөтлөгдөх зуршил тогтсон. Энэ “өвчин” дээд шатны шүүхэд ч халдварласан учир доод шатны шүүхийн зөв шийдвэрийг дээд шатанд буруутган өөрчлөх явдал гардаг болов. Ийнхүү шүүх системээрээ “өвчилжээ”. Энэ өвчинд хүний муугаас гадна бодит шалтгаан нөлөөлсөн нь үнэн: ажлын ачаалал их, шүүгчдийн ар гэр, ахуй нөхцөл дорой, шүүхийн төсөв хөрөнгө хүрэлцээгүй, эрх мэдэлтний элдэв дарамт шахалт, эргэн тойронд авилга хавтгайрсан гээд тоочвол “зовлон” барагдахгүй. Ийм байдалд хүргэхгүйн (үгүй ядаж саармагжуулахын) тулд төрөөс шүүхийг зориуд онцгойлон авч үзэх зайлшгүй шаардлагатай байсан боловч тэгсэнгүй. Ийнхүү онцлох учир нь тэнд ажиллаж байгаа хүмүүс нь бусдаас гойд илүү учраас ч биш, ерөөс нийгэм дэх хууль бус, аливаа бусармаг явдлыг таслан зогсоож шударга ёсыг тогтоох гол хэрэглүүр нь шүүх байх ёстой учраас л түүнийг аль болохоор эрүүл байлгаж, аль болохоор уул зорилго зарчмынх нь дагуу ажиллуулахын тулд төрийн бусад байгууллагатай харьцуулан барьцахгүйгээр тусгайлан авч үзэх ёстой байв. Тэгээд шүүгч нарт тэр хэмжээгээр илүү өндөр шаардлага тавьж, болохгүйгээс нь цэвэршүүлэх ёстой байсан. Гэтэл төрийн дээд удирдлагууд шүүхэд хуучин ойлголтоороо хандсаар ирэв. Түүнчлэн доод шатны шүүхүүдийг шинэ Үндсэн хуулийн дагуу бие даалгаж байгаа нь энэ гээд гэнэт зоргонд нь хаячихын оронд Дээд шүүх эхэн үед хяналтаа сулруулахгүй хатуухан барьж байгаад яваандаа зугуухан биеийг нь даалгасан бол илүү зөв байх байсан болов уу.

Шүүх нь хуулиа чандлан баримтлахгүй болохоор хууль мэдэх, хэрэглэх эрэлт хэрэгцээ, шаардлага аяндаа буурч, улмаар хэргийн оролцогч, өмгөөлөгч, прокурор нарын хэн нь хуулийг илүү мэдэж байгаа нь чухал биш, харин илүү эрх мэдэлтэй нь буюу шүүгчийг илүү “түшсэн” нь хожих болжээ. Ингэснээр мэдлэгтэй хуульчийн “ханш” буурч, эрэлт хэрэгцээгүй эд болов. Энэ бол алс хэтийн хор уршигтай үзэгдэл бөгөөд эрх зүйн нигилизмийг цаашид улам хөөргөднө.

² Харин сүүлийн жилүүдэд шийдвэрийн үндэслэлийг заах гэж оролддог болж байна.

3. Шүүх төр, нийгмийг эрүүлжүүлэгч байх ёстой

Ер нь нэг ийм хэлц үг байдаг: “парламент нь хууль гаргадаг, засгийн газар нь түүнийг зөрчдөг, шүүх нь засч залруулдаг” гэж. Тэгэхээр зохих ёсоор ажилладаг шүүхийн нийгэмд үзүүлэх хүмүүжлийн нөлөө, эрх зүйн ухамсар төлөвшихэд гүйцэтгэх үүргийг үнэлж баршгүй. Яагаад гэвэл: засгийн эрх мэдэл бүхий аливаа этгээдийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаа таслан зогсоогдохгүй байх явдал нь хүмүүсийн ухамсарт “ерөөс шударга байдал, хууль ёс гэж байхгүй юм байна, адилхан л хууль зөрчөөд зорилгодоо хүрэх нь зөв юм” гэсэн гаж ойлголт газар авч хавтгайрах нөхцөлийг бүрдүүлдэг. Төр засаг нь хууль бус, бусармаг авирлаад байхаар иргэдийн ёс суртахууныг шууд хордуулдаг. Сүүлийн үед хүний ёс жудаг муудлаа гэж яриад байдгийн учир энэ. Хэрэв засаг захиргааны хууль бус актыг шүүх тухай бүрд нь хүчингүй болгодог байвал төр захиргааны байгууллага ч асуудалд болгоомжтой, хариуцлагатай хандах хэрэгтэй болох бөгөөд иргэд ч хууль ёс, шүүхэд итгэх итгэл бий болох учиртай. Аль аль нь хууль, шударга ёс байдаг гэдэгт итгэдэг болвол нийгмийн харилцаа аяндаа эрүүлжинэ. Хууль зөрчсөн үйлдэл хийвэл шүүхээс цээрлэл хүлээдэг гэдгийг засаг захиргааны байгууллага ойлговол засаг төрийн зүгээс бусармаг үйлдэл хийх, дур зоргоор авирлах нь багасах ёстой. Улмаар төрийн албан хаагчдын эрх зүйн ухамсар, хүмүүжил, соёлын түвшинд эерэг өөрчлөлт гарах орчин нөхцөл нь бүрдэнэ. Эдүгээ төрийн албан хаагч иргэдийг элдвээр чирэгдүүлэх, ихэмсэг дээрэнгүй харилцах, хууль бус акт гаргах, шан харамж горилох, улайм цайм нэхэх, тэр бүү хэл хууль бусаар эрх чөлөөг нь хязгаарлах, өмч хөрөнгөд нь халдах зэргээр зүй бус авирлах нь хэвийн үзэгдэл болжээ. Энэ оны сүүлийн хагасаас Монгол Улсад захиргааны хэргийн шүүх ажиллаж эхэлж байна. Энэ бол одоо цагт ач холбогдлоороо Үндсэн хуулийн Цэцээс ч дутахааргүй байгууллага мөн. Захиргааны хэргийн шүүх зохих ёсоор ажиллаад эхэлбэл түшмэдийн дур зорго нь хумигдах учиртай. Энэ шүүхээр хянагдах хэргийн “холбогдогч” нь дандаа захиргааны байгууллага, албан тушаалтан байх тул “эдэлгээнд” сураагүй эмнэг догшин тэдний зүгээс шүүгч нарт элдэв дарамт шахалт үзүүлэх оролдлого гарч магадгүй. Шүүгч эхнээсээ л аливаа нөлөөнд автагдахгүй, иргэний зоригтой ажиллах нь чухал. Хүнд үед аль нэг талыг дагах юмуу, хал багатай хувилбар хайх биш, зөвхөн хуулиа л хатуу баримтлах нь дараа хэзээ ч буруутахгүй цорын ганц зөв гарц болно шүү! Харин маргаан шийдвэрлэхдээ “эхийг нь эцээхгүй, тугалыг нь тураахгүй” гэдгээр бөөрөнхийлөн зэрэмдэглэж, дундуур нь механикаар хуваадаг зуршлыг давтаж болохгүй: аль нэг тал нь дан зөв байвал 100 хувь түүний талд л шийдвэр гаргах ёстой.

Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэнд учирсан хохирлыг төр хариуцан арилгах хуультай. Өөрөөр хэлбэл, улсын төсвөөс мөнгө төлнө гэсэн үг. Гэхдээ татвар төлөгчдийн мөнгөөр төр ийнхүү тоглоод өнгөрч болохгүй. Эргээд гэм буруутай албан тушаалтанд хариуцлага тооцдог байх ёстой. Тэгсэн тохиолдолд төрийн түшмэд албан ажилдаа эрх биш хариуцлагатай ханддаг болох учиртай. Гэтэл хохирсон иргэн төрөөс гэм хор нэхдэггүй, нэхсэн ч төлдөггүй, төлсөн ч албан тушаалтанд халддаггүй болохоор ямар ч үр нөлөөгүй. Хамгийн тод жишээ гэвэл хүнийг хилсээр баривчилсан, хорьсон тохиолдолд төр хохирлыг нөхөн төлөөд дараа нь гэм буруутай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар заавал хариуцлага хүлээдэг байх ёстой. Өнөөдөр хариуцлагын ийм практик тогтолцоо алга. Гэхдээ хууль нь байхгүй биш, байгаа хуулийг хэрэглэхгүй байна. Хуулийн биелэлтийг зохион байгуулах үүрэгтэй Засгийн газар үүнийг мэдэхгүй биш (мэдэх үүрэгтэй) мэдэж л байгаа. Үнэхээр төрийн эрх баригчид хууль ёсыг жинхэнэ утгаар нь бэхжүүлэе гэвэл болохгүй гэх зүйлгүй. Тэгэхээр хүсэхгүй л байна гэсэн үг. Бүр цаашилбал хараат бус жинхэнэ шүүхтэй байхаас айдаг бололтой. Уг нь тэгэх хэрэггүй юм. Шударга алагчлалгүй шүүхтэй байх нь улс төрийн аль ч хүчин засгийн эрхэнд байсан хэрэгтэй. Эс тэгвээс шүүх нь засгийн эрх ээлжлэн барьж буй улс төрийн хүчнүүдийн хоорондын тэмцлийн зэвсэг хэрэгсэл болж хувирах аюултай. Хэрэв ингэх юм бол Үндсэн хуулиа цуцалснаас ялгаагүй. Нөгөө талаас шүүгч хүн улс төрийн үзэл бодлын хувьд дотроо өөрийн гэсэн баримтлалтай байж болох боловч үзэл бодлоо ил байтугай шууд бусаар ч илэрхийлэхийг цээрлэх ёстой. Тухайн хэргийн оролцогч нь улс төрийн өөр үзэл бодолтой хүн байлаа гэхэд түүний үйлдэл нь хууль зүйн хувьд зөв байвал шүүгч дотроо тэр хүнд хэдий дургүй байсан ч хуулийн дагуу түүний талд асуудлыг шийдэж өгдөг сэтгэлийн тэнхээтэй байх ёстой. Ингэж чадахгүй бол шүүгч биш. Тэгэхээр шударга шүүхтэй болохын төлөө чармайх нь улс төрийн бүх намуудын эрх ашигт адил нийцтэй. Үүний тулд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг төрөөс аль болохоор хангаж өгөх хэрэгтэй. Шүүхийн төсвийг үлдэгдлийн аргаар, танаж хасах замаар биш, тэргүүн ээлжинд аль болох хүрэлцэх хэмээнд нь ойртуулан хуваарилах шаардлагатай. Хэрэв Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн төсвийг хүрэлцэхээр өгөхгүй бол зардал нь дуусмагц шүүхүүд ажлаа зогсоохоос аргагүйд хүрнэ. Шүүхийн дарга нь Засгийн газраас мөнгө гуйгаад явж байж таарахгүй. Ер нь төрийн захиргааны

зардлыг үлэмж хэмнэх замаар төсвийн хүрэлцээг нэмэгдүүлэх боломж бий гэдэгт эргэлзэхгүй байна. Давхардсан олон яам, агентлаг, газар, хэлтэс, албадыг цомхотгохоос эхлээд бүр хамгийн энгийн жишээ гэхэд төрийн албанд үнэтэй автомашин хэрэглэдгийг болиулбал зохино. Хот дотор жип хөлөглөөд давхиж явах ямар хэрэг байна вэ? Солонгосын жижиг оврын суудлын тэрэг байхад л хүрээд илүү гарна шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгөөр туйлж байгаагаа ойлгодоггүй, санаа зовдоггүй юм уу? Хэрэв өндөр үнэтэй тансаг машин унахыг хүсээд байвал хувийн секторт очихгүй юу. Худалдаж идэх эрх мэдэл, албан тушаалгүйгээр бие дааж амьдрах чадваргүй хувалз шиг юмнуудаас төрийн албыг цэвэрлэхгүй бол Монголын төр ерөөс өөдлөхгүй. Шүүхэд ч энэ бас хамаатай.

Эрх зүйн ноёрхол тогтоох нэг үндсэн нөхцөл нь хуулийг нэгмөр ойлгож жигд зөв хэрэглэх явдал байдаг. Хуулийг хэн дуртай (түшмэл) нь өөр өөрийн дур зоргоор тайлбарлаад эрх мэдлээрээ түрээ барин муйхарлан зүтгэж, иргэдийн эрх ашгийг хохироох нь хэрээс хэтэрлээ. Ингэх боломж олгож байгаа хүчин зүйлийн нэг нь манай хуулийн боловсруулалт, онолын үндэс мөчид, хэл найруулга болхи, санаа нь бүрхэг, заримдаа олон салаа утгатай, хэм хэмжээ нь иж бүрэн биш, хоорондоо зөрчилтэй, нөгөө талаас Дээд шүүхийн тайлбар байдаггүй, байгаа зарим нь тодорхой бус, хуулиасаа илүү гарах юмгүй, эсхүл хэрэгцээгүй (хэрэгтэй заалтыг нь биш, мэдээжийн заалтыг тайлбарласан, тайлбар нь бүдэг, тафтологи маягтай) байгаа явдал юм. Хэрэв Дээд шүүхийн сайн тайлбар байдагсан бол дур зоргын тайлбар хийх орон зай тэр хэрээр хумигдаж, улмаар хууль бус авирлалт багасах ёстой. Жишээлбэл, татварын байцаагч хуулийг өөрийн хар ухаанаар буюу хүссэнээр тайлбарлан зүтгэдэг. Ийм асуудлаар Дээд шүүхийн албан ёсны тайлбар тэр бүр байдаггүй учир жирийн иргэн ямар ч мэргэн байлаа гээд түшмэлийн дур зоргын өмнө хүчин мөхөсдөх болдог. Тэгэхээр хуулийн талаар нэгдмэл ойлголт төлөвшүүлэхэд гүйцэтгэх үүрэг талаас нь авч үзвэл хууль ёс сул байгаагийн нэг буруутан нь яах аргагүй Дээд шүүх мөн.

4. Шүүх ямар байх нь шүүгчээс шалтгаална

“Боловсон хүчин бүхнийг шийднэ” гэдэг. Тиймээс шүүгчээр ажиллаж буй хүмүүс шүүхийн нэр хүнд, байр суурийг тодорхойлно. Ер нь шүүгчийн хараат бус байдлыг хангах гол арга зам нь дан ганц цалин нэмэх явдал биш. Өнөөдөр хахууль авч байгаа шүүгчийн цалинг сая төгрөг болгосон ч хахуулиа авсаар л байх болно. Хүний хэрэгцээ, шуналыг хангатай цалинжуулах боломж аль ч төрд байхгүй. Тиймээс гагцхүү хүн нь зөв хүн байх нь хамгаас чухал. Хүний зан төлвийн гол шугамыг тодорхойлдог төрөлх шинж, уг гарал, суурь хүмүүжил гэж нэг юм байдаг. Түүнийг нь олж харахыг л хичээх ёстой. Хүнийг судалж танихад хугацаа шаардлагатай. Барууны орнуудад хуулийн сургууль төгсөгч нь шүүгч болохын тулд урт зам туулдаг гэнэ. Жишээ нь, АНУ-д өмгөөлөгчөөр олон жил ажиллаж сайн хуульч төдийгүй зөв шударга хүн болохоо нотлон харуулсны эцэст шүүгч болдог бол ХБНГУ-д эхлээд шүүхийн бичиг хэрэг, мөрдөн байцаагч зэрэг ажилд удаан хугацааны турш дадлага хийсний дараа практикийн том шалгалтанд орж хэрэв тэнцвэл шүүгчээр ажиллах нөөц ажилтны жагсаалтад бүртгэгдээд шүүгчийн орон тоо гарах хүртэл Хууль зүйн яамны системд өөр ажил эрхэлдэг байна. Японд жил бүр хуулийн сургуулийг олон зуун хүн төгсдөг боловч шалгаруулалтанд орогчдын дөнгөж 2-3 хувь нь тэнцэж, хуульч гэгдэх эрх олж авдаг. Дараа нь тэд хуулийн байгууллагуудад 2 жилийн дадлага хийгээд дахин шалгалтанд орж тэнцсэн тохиолдолд шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажиллах эрхтэй болдог ажээ. Энэ бол зүгээр нэг хүнд суртал биш, хүнийг судалж таних арга, онож шигших механизм юм.

Тэгэхээр хүнийг зөв сонгох нь гол асуудал мөн. Угаас буруу хүний үйлс нь зөв байдаггүй, албан тушаалд гарч эрх мэдэлтэй болвол маш их гай тарьдаг. Бид нэгэнт гаднаас хуульч урьж ажиллуулахгүйгээс хойш одоо байгаа хуульчид дотроосоо хамгийн дөмгийг нь олж сонгон шүүгчээр ажиллуулахаас өөр замгүй. Үүний тулд шүүгчийг шалгаруулдаг механизмыг тун оновчтой болгох хэрэгтэй. Одоо хуульчдыг сонгон шалгаруулахдаа төсвийн аргыг зонхилон хэрэглэж байгаа нь хэлбэрийн хувьд буруу биш боловч агуулга, аргын хувьд болохгүй байна. Жишээ нь ямар хугацаагаар ял шийтгэх, хэдий хэмжээний торгууль оногдуулах, хэдэн сараар хугацааг сунгах, хэдэн хувь шимтгэл төлөх гэх мэт янз бүрийн тоо баримт асуудаг, тэр байтугай шалгалтын үед хууль, ном харж болохгүй, зөвхөн цээжээр хариулах ёстой гэдэг. Гэтэл практик дээр бол хуулиа харж байж л хэрэг, маргааныг шийднэ шүү дээ. Бүр харах харахдаа маш сайн харах ёстой. Хэдэн тоо томъёолол, зүйл анги цээжилснээр хуульч болохгүй, харин хуулийн суурь онол, зарчим, арга зүйг л эзэмшсэн байх ёстой. Хуурамч хуульчаас жинхэнэ хуульчийн ялгарах онцлог нь ердөө л энэ. Хүний ой тогтоолт, цээжний багтаамжийг шалгах нь чухал биш, харин хуулиа уншаад зөв ойлгож, зөв тайлбарлаж, зөв хэрэглэж чадаж байна уу, үгүй юу гэдэг нь л чухал. Үүний тулд

тодорхой хэргийн жишээнүүд өгөөд (урьд нь шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн жишиг ч байж болно) хууль харуулаад хэр зөв хэрэглэж байгааг нь голлон шалгамаар юм. Тийм боломж бий, тэгэх ч ёстой. Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуулийн 9.1-д сонгон шалгаруулалт нь тодорхой өгөгдлийг хууль хэрэглэж шийдвэрлэх бодлогын хэлбэртэй байна гэж заасныг практикт яг энэ утгаар нь хэрэгжүүлэхгүй байна.

Шүүгчээр ажиллуулахаар сайтар бэлтгэгдсэн хүний нөөц эдүгээ дутагдалтай байгаа нь үнэн. Тэгэхдээ мэдлэггүй хариуцлагагүй 10 шүүгчийн оронд мэдлэгтэй хариуцлагатай 5 шүүгчийг ажиллуулсан нь дээр гэж боддог. Үүнтэй холбоотойгоор ажлын ачааллын асуудал яригдах нь ойлгомжтой. Гэхдээ ачаалал гэдэг бол харьцангуй асуудал. Жишээ нь: Японы 1 шүүгчид 60 мянган хүн ам ногдож байхад манай 1 шүүгчид 7 мянган хүн ам ногдож байгаа юм. Энэ дашрамд хэлэхэд шүүхийн ачааллыг хөнгөвчлөхөд чухал үүрэгтэй эвлэрлийн шүүх байгуулан ажиллуулах асуудлыг судлан үзэх цаг болжээ. Өөр бусад олон арга зам бий. Тэгэхээр хэрэг, маргааныг түргэн шуурхай атлаа буруу шийдвэрлэдэг байснаас алгуур боловч үнэн зөв шийдвэрлэж байвал дээр биш үү? Монгол Улсын Засгийн газрын эсрэг “Марубени” компанийн гаргасан нэхэмжлэлтэй хэргийг Лондонгийн шүүх авч хэлэлцээд хурлаа завсарласан боловч шийдвэрээ 2 сарын дараа гаргах юм гэнэ гэж хэвлэлд мэдээлж байв. Гэтэл манай шүүхийн практикт аливаа хэргийг нэг амьсгаагаар буюу нэг хурлаар (гол төлөв хэдхэн цагт буюу нэг өдрийн дотор) яаруу сандруу хам хум шийддэг заншил хэвээр үргэлжилсээр. Тэгэхдээ үүний цаад хор уршиг нь яаруу түргэндээ ч байгаа юм биш, харин шүүх хуралдаанаар “амьд” нотлох баримтыг нүдээр үзэж гараар барьж, тал бүрээс нь нягтлан тунгаасны эцэст гаргах ёстой шийдвэрийг урьдаас бүрдүүлсэн хэргийн материалыг уншаад төрсөн сэтгэгдэлдээ хөтлөгдөн шүүх хурлаас бүр өмнө цээжиндээ аль хэдийнэ гаргачихсан байдаг л оршино. Тэр байтугай шүүх хуралдаанаас өмнө шийдвэрийнхээ төслийг зарим шүүгч урьдчилан бичээд бэлдчихсэн байдаг нь нууц биш. Ялангуяа шүүх хурал дээр шүүгч таныг яаруулан шавдуулаад, үг гүйцэд хэлүүлэхгүй таслан зогсоогоод байгаа бол шийдвэрээ түрүүлээд гаргасны шинж.

Хамгийн гол нь хэрэг, маргааныг санаатайгаар буюу илтэд буруу шийдвэрлэсэн шүүгчид хариуцлага хүлээлгэдэг механизм үгүйлэгдэж байна. Шүүхийн ерөнхий зөвлөл болон Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүний дийлэнх олонх нь шүүгчдээс бүрдэж байгаа учир олгой хагаравч тогоон дотроо гэгчээр байгууллагын явцуу ашиг сонирхол хэмээх архаг өвчний синдром амь бөхтэй үйлчилсээр. Шүүгчид нэр дэвшигчийг шалгаруулах шалгалтын босгыг өндөр байлгаж байгаа нь энэ гээд механик хаалт хориглолт шиг юм хийж болохгүй. Шалгаруулж буй одоогийн арга барил нь зөв хүмүүжилтэй, илүү боловсролтой хүн шүүхийн системд гаднаас нэвтрэн орох боломж бараг олгодоггүй, хамгийн гол нь тухайн нэр дэвшигч хүмүүжил, ёс суртахууны хувьд тэнцэх эсэхийг магадлан шигшдэг шүүлтүүр байхгүй учир тохиолдлын хүн шүүгч болох үүд нээлттэй байна гэсэн үг. Хүмүүжил, ёс суртахууны төлөвшил, боловсрол, соёл муутай хүн шүүгч болохоороо эрх мэдлээ урвуулан ашиглаад зогсохгүй иргэдтэй догшин ширүүн харилцах, аашилж загнах, ярвайж ихэмсэглэх, дайрч доромжлох зэргээр бүдүүлэг авирладаг. Шүүгч нар хүнийг их загнадаг гэх юм. Тийм эрх шүүгчид байхгүй шүү! Тэр тусмаа шүүгч бол хэрэг, маргаанд оролцогчийн дарга нь биш. Харилцааны ийм зөрчил гаргадаг хүн ёс зүйн хувьд шүүгчид тэнцэхгүй.

Сүүлийн жилүүдэд гадаадын төслийн санхүүжилтээр шүүгчдийг давтан сургахад чамгүй зардал, цаг хугацаа, хөдөлмөр зарцуулж байгаа бололтой. Энэ бол зайлшгүй арга хэмжээ мөн. Гэхдээ хөрөнгө оруулалтыг хуучин (хуучинсаг) кадрүүдэд биш, ирээдүйгээ харж шинэлэг сэтгэлгээтэй, “бохирдоогүй” шинэ боловсон хүчин бэлтгэхэд түлхүү зориулмаар байна. Ер нь 1990 оноос өмнөх үед тооны хичээлд сайн, “толгойтой” хүүхдүүд хуулийн сургуульд явдаггүй, гол төлөв тооноос зугтсан нь хуулийн сургуульд хуваарилагддаг байсан учир тэр үед бэлтгэгдсэн олонх (бүгд биш л дээ) хуульчид маань сэтгэх чадвар буюу одоогийн хэллэгээр iQ-ийн хувьд гологдох болжээ. Монголын Оюуны чадварын төвөөс Хуульчдыг бэлтгэх төв болон нийслэлийн шүүхтэй хамтран хуульчдын дунд хийсэн судалгаагаар тэдний дундаж iQ нь дээд мэргэжилтэй хүний хувьд хангалтгүй үзүүлэлттэй гарч, тал хувь нь мунхагдуу гэсэн ангилалд хамаарах үнэлгээ авчээ³. Монголын Оюуны чадварын төвийн энэхүү мэдээлэлд “АНУ-д хуульчийн iQ нь 130-аас доошгүй байх ёстойг хуульчлан мөрдүүлжээ. Хуулийн мэргэжлээр их дээд сургуульд элсэгчдийн сэтгэх чадварыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллага (ETS-боловсролын төстийн алба) нь стандарт тест (LSAT-хуульч мэргэжлээр сурах чадварын тест)-ээр шалган эрэмбэлж 130-аас

³ “Өдрийн сонин”, 2003.04.30, №104

доош иО-тай бол элсэх эрхийг хасдаг аж. ... Монголын хуульчдын сэтгэх чадвар цаг үеийн шаардлагаас илт хоцорч байна. Үүний уршгаар манай хуулийн шударгаар үйлчлэх чадавхи буурч, нийгмийн доод дунд давхаргад хатуурч, дээд давхаргад зөөлрөх аястай болжээ. Энэ оноос (манайх) хуульчдыг сонгон шалгаруулж эхлэх нь. ... Мэдээж хэрэг сонгон шалгаруулах үзүүлэлтийн эхэнд сэтгэх чадварын оноо байж таарна. Ингэхгүй бол архаг хуучинсаг нь орон зай эзэлж, залуус шахагдаж, байдал дордоно” хэмээн анхааруулсан байна. Гэтэл энэ онд явагдсан хуульчдыг шалгаруулах болон захиргааны хэргийн шүүхийн шалгаруулалтын асуултанд сэтгэх чадварын асуулт ерөөс ороогүй бололтой байх юм.

1990 оноос хойш хуульч бэлтгэдэг сургалтын чанар улам муудсан гэдэг нь илт мэдрэгдэж байна. Гэтэл гол төлөв ийм эх үүсвэрээс шүүгч, бусад хуульчдыг нөхөн хангаж байгаа нь үнэхээр харамсалтай бөгөөд хор уршигтай. Сургалтын чанарыг сайжруулахын тулд багш нарыг чанаржуулах нь чухал. Оюутнууд багшаа илт голдог болж. Харьцангуй хямдыг нь бодвол ОХУ-аас багш урьж ажиллуулахад болохгүй гэх газаргүй, манай багш нараас яасан ч дор орохгүй байх. Зардал нь тэртэй тэргүй оюутнуудын эцэг, эхээс л гарах юм чинь, арай гайгүй юманд мөнгөө төлсөн нь дээр биз дээ. Эдүгээ орой, эчнээ, их дээдийн ч гэх шиг, эдийн засаг, хэлний сургууль хүртэл хуульч бэлтгэх нэрээр “гурилддаг” болж. Хичээлд суухгүй, ном уншихгүй, дадлага хийхгүйгээр хуульчийн диплом авдаг дарганцарууд өөрсдийгөө хуульч мэргэжилтэй гээд хэв нэг анкетандаа бичээд гайхуулж явах юм. Надаас бусад нь бараг бүгд хууль зүйн шинжлэх ухааны магистр, доктор гэгдэх болжээ.

Хуульчдын дотроос шүүгчийг шилж сонгох эрх, үүрэгтэй этгээд нь Үндсэн хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл. Ерөнхийлөгч бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн шилж сонгоод шүүгчээр томилоход болно гэж нэгэнт шийдвэрлэсэн хүнийг зөвхөн ёсчлон батламжилдаг эрхтэй. Хэрэв Ерөнхийлөгч хэнийг томилох, хэнийг эс томилох эрх мэдэлтэй байвал шүүгч нар түүнээс хараат болохоос гадна Ерөнхийлөгч тийнхүү томилсон хүмүүсийнхээ зөв буруу, сайн муугийн төлөө бас давхар хариуцлага үүрэх хэрэгтэй болно шүү дээ! Гэтэл Шүүхийн тухай (2002 оны) хуулийн 32.8 дугаар зүйлд ерөнхий шүүгч болон шүүгчээр томилохоос Ерөнхийлөгч татгалзвал Шүүхийн ерөнхий зөвлөл өөр нэр дэвшигчийг санал болгоно гэж зааснаас үзвэл шүүгчид тэнцэхгүй хүн томилогдсоны бурууг Ерөнхийлөгч хуваалцах ёстой мэт болжээ. Энэ утгаараа шүүхийн ажил муу байвал Ерөнхийлөгчтэй бас холбоотой болох нь.

5. Дээд шатны шүүхийн хяналт чухал

Үндсэн хууль болоод Шүүхийн тухай хуулиар шүүх болон шүүгч гадны нөлөөнд автагдахгүй байх баталгаа эрх зүйн хувьд бүрдсэн учир нэгэнт шүүгчээр томилогдсон хүн өөрөө илт ноцтой зөрчил гаргахгүй л бол түүнд шийтгэл ногдуулах, тэр тусмаа ажлаас нь зайлуулах боломж байхгүй. Ийм нөхцөлд шүүхийн алдаа дутагдлыг засч залруулах цорын ганц механизм нь дээд шатны шүүхийн хяналт юм. Тэгэхдээ дээд шатны шүүх нь тодорхой хэргийг яаж шийдэх, ямар ял зэм ногдуулах талаар урьдчилан чиглэл өгөх эрхгүй боловч доод шатны шүүхийн гаргасан алдааг засч залруулах үүрэгтэй. Энэ утгаар дээд шатны шүүхийн зүгээс доод шатны шүүхийн ажиллагаанд тавих хяналт нь шүүхийн алдаа завхралыг засах, ерөөс нийт шүүхийн ажлын чанарын үзүүлэлтийг тодорхойлох чухал хэрэглүүр мөн. Түүний ач холбогдол, эрэлт хэрэгцээ нь зарим шүүгч нар хэргийг харсаар байтал илт буруу шийдвэрлэж хүнийг хохироох нь хэрээс хэтэрч буй энэ үед улам бүр хурцаар мэдрэгдэх болов. Илтэд буруу шийдвэр гаргаж буй шалтгаан нь нэг бол мэдлэг дутсаных, эсхүл зориудынх байдаг. Тэгэхээр илэрхий асуудлыг мэдэхгүй байгаа бол шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй байна гэсэн үг. Хэрэв зориуд буруу шийдвэр гаргасан бол бүр ч тэнцэхгүй, харин гэмт хэрэг учир нэн даруй зайлуулах хэрэгтэй гэсэн үг. Дээд шатны шүүх асуудалд энэ үүднээс хандвал нааштай өөрчлөлт гарах боломж бий. Тэгэхдээ шүүх бүрэлдэхүүний бие даасан байдал, дээд шатны шүүгч нь доод шатны шүүгчийн “дарга” биш гэх мэт шүүхийн тогтолцооны үндсэн зарчмуудыг хөсөрдүүлж болохгүй. Эдүгээ анхан шатнаас эхлээд Дээд шүүх хүртэл бүх шатны шүүх хэрэг маргааныг туушд нь буруу шийдвэрлэх явдал цөөнгүй гардаг бөгөөд энэ тохиолдолд одоогийн хуулиар Дээд шүүхийн ерөнхий шүүгч эцсийн удаад дүгнэлт бичдэг онц эрхтэй. Гэтэл Ерөнхий шүүгч нь шал буруу, хууль бус дүгнэлт гаргасан тохиолдолд гомдогч үндсэндээ мухардалд ордог. Ийм нөхцөлд Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг Үндсэн хууль зөрчсөн гэдэг үндэслэлээр Цэцэд өгөх боломж онолын хувьд бий боловч тийм гомдлыг Цэц хүлээн авч шийдвэрлэсэн гэж би л лав дуулаагүй.

6. Шүүх ба хуулийн бусад байгууллага

Шүүхийн нэр хүнд, үр нөлөө нь хуулийн бусад байгууллагын ажил ямар байгаагаас зайлшгүй шалтгаална. Мөрдөн байцаалт чанаргүй, прокурорын хяналт сиймхий, шүүхийн шийдвэр гүйцэтгэл зогсонги байвал шүүн таслах ажлын үр нөлөө ямар олигтой байх билээ.

Хуулийн байгууллагын үйл ажиллагаанд улам бүр тод ажиглагдах болсон нэгэн ноцтой хандлага бол "нотолж чадаагүй бол гэм буруутайд тооцож болохгүй" гэдэг зарчмыг хайхрахаа больж буй явдал юм. Хүнийг хуулийн үндэслэлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, цагдан хорих, тэр байтугай ял шийтгэх нь тохиолдлын шинжтэй биш, ер нь хэвшмэл практик болох янзтай. Мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг гээд шуугиулсан алив асуудлыг шүүх ч гэсэн "зажилахгүй залгих" бололтой. Хэрэгт сэжиглэгдсэн этгээд ямар ч муу нэртэй хэн ч байлаа гэсэн хуулийн дагуу гэм бурууг нь хөдөлбөргүй баримтаар нотолж чадаагүй л бол хичнээн ч их хардлага сэжиглэл байлаа гэсэн хариуцлагаас чөлөөлдөг байх ёстой! Ингэвэл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын ажилд ч хөшүүрэг болж өгөх сайн нөлөөтэй. Яагаад гэвэл тэд хэрэг шалгах ажиллагааг хялбарчлан халтуурдахгүйн тулд илүү чармайх, муйхарлах биш толгой ажиллуулах хэрэгтэй болно. Аливаа хууль бус арга барилыг нийгмийн шударга ёс, гэмт хэрэгтэй тэмцэх гэх мэт ариун дэвэргэн зорилт лоозонгоор халхавчлан зөвтгөж, улс төржүүлэн хөөргөдөг болохгүй. Энэ хамгийн аюултай. Өөрөөр хэлбэл "зорилго нь аргаа зөвтгөх" зарчим хуулийн практикт үндсээрээ харшилна. Хилсээр нэг хүн шийтгэснээс хэрэг хийсэн гурван хүнд ял завшуулсан нь дээр. Аливаа хэлмэгдүүлэлтийн машин нь эргээд "зохион бүтээгч"-ийгээ залгидаг жамтай! Хууль бусаар хүнийг эрүүгийн хариуцлагад татсан, цагдан хорьсон, ял шийтгэсэн хуулийн байгууллагын ажилтан гэм зэмгүй өнгөрч таарахгүй. Одоо цагдан хорих зөвшөөрлийг шүүгч өгдөг болсон нь прокурорын эрхийг танаж, шүүгчийн эрхийг өргөтгөж байгаа хэрэг бус, харин хүний эрхийг хамгаалахад шүүхийн хариуцлагыг нэмэгдүүлж байгаа юм. Эрх мэдэл нэмэгдэхийн хэрээр үүрэг хариуцлага нь хүндэрдэг учрыг санаж, хүнийг цагдан хорихоор цагдаа, прокуророос тавьсан саналд шүүгч туйлын болгоомжтой, хариуцлагатай, бүр "харамч" хандах үүрэгтэй бөгөөд алдаа гарвал эцсийн хариуцлагыг шийдвэр гаргасны хувьд шүүгч л хүлээх болно шүү!

Практикаас ажихад ноцтой том хэргийн нэрээр хүнд эрүү үүсгэж, олон сар, жилээр хорьж мөрдөөд нотлогдохгүй буюу тийм хэрэг хийгээгүй болох нь нотлогдоод ирэхээр алдаагаа нуухын тулд өө сөв хайн, ялих шалихгүй хэрэг зүүж шийтгүүлэн золиосолдог "туршлага" дэлгэрэх төлөвтэй. Энэ бол хэлмэгдүүлэлтийн үеийн сэтгэлгээний уламжлал мөн. Анх эрүү үүсгэх шалтгаан болсон хэргийг нь нотлон тогтоож чадаагүй л бол явцын дунд илэрсэн хөнгөн хэргээр торгоох гэж оролддог арчаагүй аргыг халах хэрэгтэй. Энэ асуудлыг хуулиар зохицуулж болно.

Хуулийн байгууллагын практикт эд хөрөнгийн маргааныг эрүүгийн хэрэг болгон шалгаж, хүнийг хилсдүүлэх явдал улам бүр газар авах боллоо. Хамгийн түгээмэл жишээ нь зээл аваад төлж чадаагүй ердийн нэг иргэний хэргийг цагдаа нар танил талын захиалгаар залилан мэхэлсэн эрүүгийн хэрэг болгон зүтгүүлж, тэр нь прокурор, шүүх дээр ч торохгүй өнгөрдөг болсон гэх юм. Энэ бол хуулийн байгууллагын ажилтан албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж буй гэмт хэрэг мөн.

Хэдийгээр үр дагавар нь ноцтой боловч болгоомжгүйн улмаас гэмт хэрэг (хүний амь нас эндсэн авто осол г.м.) анх удаа үйлдсэн этгээдийг цагдан хорьдогийг болих хэрэгтэй! Ерөөс юм л бол хорино цагдана гэж сүрдүүлдэг, хорих баривчлах явдлыг хэрэг хүлээлгэдэг үндсэн аргаа болгосон байна. Гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлэхийн тулд шүүхүүд ялын бодлогыг чангатгах чиг барьж байгаа гэх юм. Хатуу ял оноосноор гэмт хэрэг багасдаггүй нь аль хэдийнэ нотлогдсон аксиом шүү дээ!

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хууль болон эрх зүйн ухамсарыг удирдлага болгон нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ гэж хуульд заасан байдаг. Гэтэл практик дээр хуулийн байгууллагын зарим ажилтан аливаа хэрэг, маргааны талаар гаргасан шийдвэрээ олон нийтийн өмнө хамгаалан тайлбарлахдаа хэргийг өөрийн дотоод итгэлээр шийдсэн гэж мэдэмхийрч байгаа нь би юу гэж ойлгоно, түүгээр л шийдэх ёстой гэсэн санаатай. Дотоод итгэл гэдгийг тухайн албан тушаалтны хүсэл, эмоци, үзэмжээс үүдсэн дур зоргын ойлголттой хольж болохгүй. Нэгэнт хөдөлбөргүй батлагдсан үнэн зөв бодит үйл баримтад үндэслэсэн гарцаагүй үнэмшил бүхий ойлголтыг л дотоод итгэл гэдэг. Бага боловч эргэлзээ байвал дотоод итгэлийн тухай ярих ч ёсгүй.

Эрүү, иргэний шүүн таслах ажиллагаа мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явагдах болсон одоо үед хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд талуудын өмгөөлөгчдийн болон яллагчийн аль илүү хууль зүйн болоод логик үндэслэлтэй, үнэмшилтэй, мэдлэгтэй тавьсан тайлбарыг шүүх анхааралтай сонсож, шийдвэр гаргахдаа харгалзан үздэг байвал шүүхээс зөв шийдвэр гаргахад ч хэрэгтэй, ялагч, өмгөөлөгчдийн мэдлэг чадвар дээшлэхэд ч түлхэц болох ёстой. Өмгөөлөгчдийн олонх нь мэргэжилдээ муу байгаа явдал ерөөс өмгөөллийн үнэ хүндийг шүүхийн өмнө бууруулж байгаа нь бас үнэн. Өмгөөлнө гэдэг бол өмөөрөхийн нэр биш. Буруу зүйлийг улайран хамгаалахыг өмөөрөх гэнэ. Одоогийн өмгөөлөгч нар хуулийг мэддэг ба шүүгчийг таньдаг гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэж байна. Сүүлийнхэн хэрэгтэй зүйл хэлдэггүй учир шүүхээс зөв шийдвэр гарахад нэмэр болдоггүй атлаа эцсийн үр дүн буюу ялсан хэргээр эхнийхээс давамгайл. Зүй нь юм мэддэг өмгөөлөгчийн гарцаагүй зөв саналыг шүүх шийдвэртээ тэр чигээр нь тусгасан ч, иш баримт болгосон ч болохгүй гэх зүйлгүй. Тэгэхээс ичиж нэрэлхэх хэрэггүй. Харин ч бусдын зөв мэргэн санааг тусган авах чадвартай гэдгээ харуулбал тухайн шүүгчийн нэр хүндэд л хэрэгтэй. Гэтэл өмгөөлөгч ямар ч зөв сайн тайлбар гаргалаа гэсэн шүүгч түүнээс заавал өөрөөр шийдвэрлэх албатай юм шиг буруу, дутуу, зэрэмдэг, бөөрөнхий шийдвэр гаргадаг. Ингэснээр юу ч хэлээд нэмэргүй мунхаг гэж өөрийгөө харуулна.

Эрх зүйт төрийн уламжлалт тогтолцооны жишгээр бол эрүүгийн мөрдөн мөшгих онц бүрэн эрхийг гагцхүү прокурор хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, аливаа асуудлыг эрүүгийн журмаар шалгах эсэхийг зөвхөн прокурор шийддэг байх ёстой. Гэтэл 1993 онд Прокурорын байгууллагын тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэх үед зарим нөхөд мэдэмхийрч үзэл баримтлалын бүтцийг нь эвдээд, дараа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 1994 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа прокурорын процессийн эрх, үүргийг юу ч үгүй болтол танаж хассаны уршгаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг прокурорын хяналтаас гарган, энэ салбарт цагдаа ноёрхож, хууль ёс завхруулах нөхцөлийг бүрдүүлж өгсөн. 2002 онд ЭБШ хуульд зарим өөрчлөлт оруулсан боловч прокурор өлбөгөр, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар нь түүнийг үл тоодог хэвээр. Гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй асуудлаар хүнийг эрүүгийн хэрэгт холбогдуулан олон сар, жилээр чирэгдүүлэн залхаадаг атлаа албан тушаалтнууд ноцтой гэмт хэрэг үйлдсэн тухай илэрхий мэдээ сэлтийг шалгахаас зайлсхийнэ.

Цагдаагийн байгууллагын тухайд бол дампуурсан гэхээс өөр хэлэх юм алга. Бараг эмчилгээгүй болсон байхаа.

Эрх зүйн нигилизмийн намагт гүнзгий шигдсэн хуулийн байгууллагыг системээр нь эрүүлжүүлэхийн тулд эрс шийдэмгий цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

1990-1993 онд Монгол Улсын
Ерөнхий прокурор асан Г.Бахдал